

Д.МӨНХТӨР

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологич

ТЕЛЕВИЗИЙН ХУВЬСГАЛ ба 1989 оны 12 сарын 7-ны ХОВДЫН ХӨДӨЛГӨӨН⁶⁷

“Хүмүүс түүхээ бүтээдэг юм, гэхдээ өөрсдийн
хүссэн нөхцөлийн дотор бус...”

К. Маркс

/Энэхүү өгүүлэл нь Монгол дахь ардчиллын төлөөх анхны эсэргүүцлийн цуглаан болох 1989.12.07-ны Ховдын цуглаанд оролцогсдын зүгээс, тухайн цуглааны 20 жилийн ойд зориулан 2009 онд эмхэтгэн хэвлүүлсэн “Эрх чөлөөний эрэлхийлэл” хэмээх номын удиртгал юм. Уг удиртгал нь тухайн үйл явдалд оролцсон хүний дурсамж төдийгүй мөн нийгмийн хөдөлгөөний социологийн анализыг өөртөө багтаасан, социологийн шинжлэх ухааны хувьд үнэ цэнэтэй гэж үзсэн учраас зохиогчийн зөвшөөрөлтэйгөөр дахин хэвлэж байгаа болно. Даширамд дурдахад уг номонд зохиогчийн бичсэн социологийн анализ бүрэн хэвлэгдээгүй бөгөөд энэ сэтгүүлд бүрэн эхээрээ хэвлэгдэж байна.

Ред. Ц.Болд /

Хүн бүр өөр өөрийн хувь тавилантай, түүнийгээ өөрсдөө бий болгодог шиг, түүхэн үйл явдлууд ч басхүү өөр өөрийн тавилантай байх аж. 1206 оны Их Монгол улс ч тэр, 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, 1921 оны Ардын хувьсгал ч тэр, 1989 - 1990 оны Ардчилсан хөдөлгөөн ч тэр, энэхүү жамыг тойрон гарсангүй. 90-ээд оны Ардчилсан хувьсгалын анхны томоохон дэлбэрэлтүүдийн нэг Ховдын хөдөлгөөн ч үүнд бүрнээ хамаарагдана. Ховдын хөдөлгөөн нь, гадаад болон дотоод нөхцөл байдлын өөрчлөлтүүдийн нөлөөгөөр, өөрчлөн байгуулалтын үйд явцыг хурдасгахыг хүлээсээр тухайн үеийн Төр засгийн удирдлагуудын хөшүүн байдал, хүсэл эрмэлзэлгүй байдалд тэвчээр барагдан улс орон даяар дэлбэрэхэд бэлэн болоод байсан үеийн хөдөлгөөний анхны нэг жишээ нь юм. Уг нь МАХН-ын 1988 оны 5-р Бүгд Хурал анхандаа нийгмийг хөдөлгөөнд оруулахуйц амьсгалыг авчирсан боловч түүнээс хойш бараг нэг жил өнгөрөхөд энэ нь түүхэн цаг үеэ мэдрэх чадамжгүй болсон хуучин системийн түр зуурын амиа аргацаалт байсан гэдэг нь илт тодорхой болж ирсэн юм.

Түүхэн томоохон үйл явдлын өрнөлийг, зохион байгуулагчид нь юм уу эсвэл судлаачид урьдчилан төсөөлдөг, тооцоолдог авч “харамсалтай нь” бодит байдал дээр үйл явдлын үр дүнгүүд нь тэдний яс тооцоолсноор, төлөвлөснөөр бүтэх нь туйлын бага байдаг. Үүнийг Өрнөдийн нийгэм судлаачид “түүхийн хүлээгдээгүй үр дүнгүүд” хэмээх оноолтод оруулан, түүхийн социологийн нэгэн чухал зарчим болгон авч үзэж байна.

1989.12.07-ны өдөр Ховд хотноо, Ард Аюушийн талбайд болсон энэхүү цуглааныг үнэлж дүгнэхэд ч дээрх санаа аргазүйн хувьд онцгой ач холбогдолтой юм.

Энэ өдөр хаана юу болсон талаар зохион байгуулсан, оролцсон оюутан залуус болоод бусад хүмүүсийн дурсамж, тэмдэглэлүүдээс уншигчид хангалттай олон талын мэдээллийг олж

⁶⁷ Юуны өмнө эл удиртгал үгийг бичиглэгч би вээр өөрийн байр суурийг шууд тодруулан хэлэх нь зүйтэй хэмээн санана. Нэгд, би уг үйл явдлыг “хөндлөнгийн нүд”-ээр харж бичсэнгүй. Хоёрт гэвэл, би хувь хүнийхээ хувьд нийгмийн шинжлэх ухаанд “хөндлөнгийн нүд” гээч юм байдаггүй гэсэн аргазүйн баримтлалыг итгэл үнэмилээ болгосон нэгэн болно. Энэ бүхнийг эш үндэс болгон би эл удиртгал үгийг, тухайн үйл явдалд оролцож байсан хүний хувьд эмоциосоо “нүүр буруулагүйгээр”, басхүү социологи, нийгмийн ухааны салбарт хөлс хүчээ үнэлж, хүмүүний нийгмийг ойлгохыг сонирхон оролдог хүний хувьд оюун ухаанаасаа “урваж шарвалгүйгээр” бичихийг оролдсон болно. Д.М

авах нь гарцаагүй. Тиймээс би энд, илүү товч бөгөөд тодорхой харагдуулах үүднээс уг үйл явдлыг дараахь байдлаар багцлан тодорхойлохыг оролдов.

1989 оны 12 сарын 07-ны үйл явдлын товчоон:

- **Хэзээ**
1989 оны 12 сарын 07-ны Пүрэв гарагийн 14.00 цагаас
- **Хаана**
Ховд хот, Ард Аюушийн талбайд
- **Юу болсон**
Монголын түүхэн дэх Ардчиллын төлөөх анхны улс төрийн эсэргүүцлийн цуглаан зохион байгуулагдсан
- **Цуглааныг санаачлагчид**
ХоБДС-ийн оюутнууд
- **Хэн зохион байгуулсан**
Ховдын Багшийн Дээд Сургуулийн нэр бүхий 10 гаруй оюутан, 3 багш
- **Хэн оролцсон**
Ховдын Багшийн Дээд Сургуулийн оюутан, багш нар, мөн Ховд хотын иргэд нийлсэн 300 орчим хүн
- **Хаанаас хөдөлсөн**
ХоБДС-ийн хичээлийн байрын урд талд орших оюутны 2 байрын дундах талбайгаас
- **Зорилго**
Өөрчлөн байгуулалтын үйл явцыг түргэсгэх, ардчиллыг хөгжүүлэх
- **Гол шаардлага**
МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо, Сайд нарын Зөвлөлийг бүрэн бүрэлдхүүнээр нь огцруулах
- **Гаргасан бичиг баримт**
Цуглааны гол шаардлагыг агуулсан “Өргөх бичиг”
- **Өргөх бичгийг хэн эцэслэн боловсруулсан**
Зохион багуулагчдын дунд ярилцаж тогтсон санааг МХУЗ-ын тэнхмийн багш С.Энхбаяр
- **Өргөх бичгийг хэнд өгсөн, хааш нь хүргүүлсэн**
Ховдын Намын хорооны 1-р нарийн бичгийн дарга Д. Буяндэлгэрт гардуулж, МАХН-ын ҮИ Бүгд хуралд хүргүүлсэн,
- **Өргөх бичгийг хэн, хаана өгсөн**
Цуглаанаас томилогдсон багш Ц. Батзангиа, Д. Мөнхтөр, оюутан С.Эрдэнэцогт, А.Эрдэнэбаатар нар аймгийн захиргааны 2-р давхарт байрлах, Намын хорооны 1-р нарийн бичгийн дарга Д. Буяндэлгэрийн ажлын өрөөнд нь
- **Хэрхэн хүлээж авсан**
Өргөх бичгийг аваад, гадаа талбайд цуглаан хийдэг чинь буруу байна, та нар Төв Хороо руу хандахаасаа өмнө аймаг орон нутгийнхаа асуудлыг ярь л даа гээд аймгийнхаа ажлыг хэрхэн сайжруулж буйтай холбоотой баахан лекц уншихыг оролдсон. Өргөх бичгийг өгнө гэсэн. Бид байр сууриа хамгаалан маргалдах маягтай үг ч хэлэлцсэн, харин биднийг буруугаа хүлээгээд гарсан гэх маягтай танилцуулгыг Товчооны хуралдаан хийж нөхөр 1-р дарга арьсаа хамгаалсан байв.
- **Өргөх бичиг хаана хүргэгдсэн**
Д. Буяндэлгэр дарга Улаанбаатараас эргэж ирээд БДС-ийн багш ажилчидтай уулзсан. Тэр үед асуухад Төв Хорооны Ерөнхий хэлтэст өгсөн. Нухацтай судалж үзнэ гэсэн хариу өгсөн гэв. Хэрвээ үнэхээр Ерөнхий хэлтэст өгсөн бол архивт нь байх ёстой
- **Барьсан уриа лоозонгууд**
“Залуусаа Монгол улсынхаа төлөө нэгдэцгээе”, “Өөрчлөн байгуулалт шинэ удирдлага шаардаж байна”, “Өөрчлөн байгуулалтыг хурдасгахыг МАХН-ын 7-р бүгд хурлаас шаардаж байна” 3 ширхэг том лоозон, мөн ийм төрлийн агуулга бүхий 14 ширхэг уриа, Чингис хааны “Алд бие минь алжааваас алжаатугай, Аху төр минь бүү алдартугай” хэмээх үг бүхий 3 ширхэг зурмал хөрөг, мөн үг бичсэн толгойн туузан боолтууд
- **Хэн цуглааныг нээж үг хэлсэн**

- ХоБДС-ийн Оюутны зөвлөлийн дарга, МХУЗ-ын 4-р ангийн оюутан С. Эрдэнэцогт
- **Цуглаан дээр хэдэн хүн үг хэлсэн**
Багш, оюутнууд, цуглааныг ажиглахаар ирсэн хүмүүсээс Ховд хотын 4 иргэн нийт 20 орчим хүн
 - **Ашигласан техник хэрэгслүүд**
Тавцан болгож 4 ширхэг мухар сандал, сургуулийн клубийн чанга яригч, цахилгааныг гудамжны гэрлийн монтажаас холболт хийсэн
 - **Цуглаан хэрхэн баримтжуулагдсан**
Үнэн сонины Ховд аймаг дахь сурвалжлагч Т. Цоож цуглаан дундаа орж байхад гарч ирэн цөөн хэдэн зураг дарсан, мөн аймгийн захиргааны байшин дотроос, цонхны цаанаас Намын хорооны зааварлагч Д. Мөнхцоож камераар бичлэг хийсэн. Үүнийг дараа нь, тухайлбал Аймгийн хэвлэх үйлдвэр зэрэг зарим байгууллагын хурал дээр үзүүлсэн байсан.
 - **Цуглаан хэдэн цаг үргэлжилсэн**
2 – 3 цаг
 - **Яаж тарсан**
“Эх орон” дууг дуулж, Аюушийн талбайг нар зөв тойрон БДС-ийнхаа оюутны байр луу жагсаалаараа явжээ.
/”Бүргэд цуцам халил хадандаа
Буурал тэхүүд сүрэглэн наадсан
Хараа булаам тэнэгэр говьдоо
Хулангийн сүрэг хуйлран наадсан
Миний эх орон сайхан орон
Минж булгын сор шиг орон” гэсэн үгтэй/
 - **Цуглааны хүлээлт**
Юуны өмнө Бүгд хурлаас ирэх хариуг хүлээж, түүнээс хамааран дараагийн арга хэмжээг төлөвлөхөөр зохион байгуулагчид дотроо ярилцаж тогтсон байв.
 - **Мэдээллийн хэрэгслээр гаргахыг оролдсон эсэх**
Өргөх бичиг гардуулсан төлөөлөгчид Д. Буяндэлгэрийн өрөөнөөс гараад шат руу бууж явахад Монголын Радиогийн Ховд дахь сурвалжлагч Банзрагч доороос гарч ирж таараад, юу болоод өнгөрөв өө би юманд явж байгаад сая мэдлээ ярилцаж гэж байснаа, юу ч болсон би эхлээд дарга дээр орчихоод ирье, хүлээж байгаарай гээд дээш гарсан. Хэсэг хуугацааны дараа гарч ирэхдээ за за дараа уулзая гээд илт зайлсхийгээд явсан. Харин дараа нь товчооны хуралд Банзрагч гуайтай уулзахаас биднийг зайлсхийсэн тухай мэдээлэл өгөгдсөн байв. Үнэн сонины сурвалжлагч Т. Цоожтой 12.08-нд Д. Мөнхтөр уулзаж энэ талаар сонины мэдээлэл гаргаж өгөхийг хүссэн. Т.Цоож: Үнэн сонины коллеги хэвлэхгүй дээ, би мэдэж байна. Харин над материал, зураг зэрэг байгаа дараа хэрэг болбол аваарай гэж тухайн үед нь үнэнийг хэлж байсан. Намын байгууллагуудын шугамаар л энэ талын мэдээлэл аймгуудад тараагдсан бололтой. Жишээ нь, Булган аймгийн ХЗЭ-ийн байгууллагын гишүүд ч гэл үү “Залуучуудын үнэн” сонинд эсэргүүцэл ч билүү гомдол ч билүү хэвлүүсэн байсан.
 - **Хожим Мэдээллийн хэрэгслээр цацагдсан байдал**
-“Тусгаар тогтнол” сонины сурвалжлагч, дэд хурандаа Х. Шагдар “Монголын залуучууд” сонины 1992.06.26-ны №18-д “Аюушийн талбай амь орсон нь” нэртэй нийтлэл хэвлүүлсэн.
-Мөн уг жагсаалаас 1 жилийн дараа Ховд аймагт Монголын Радиогийн сурвалжлагчаар очиж ажиллаж байсан сэтгүүлч Ц. Дашдамба Ардчилсан хөдөлгөөн эхэлсний 5 жилийн ойтой холбогдуулан оролцож байсан зарим хүмүүсээс ярилцлага авч, 1994.12.07-ны өдөр Радиогоор Ховдын цуглааны талаар нэвтрүүлэг хийсэн.
-1997 оны 1-р сарын эхээр уг цуглааныг зохион байгуулсан зарим хүмүүс оролцсон ярилцлагыг Монгол телевизэд өгсөн боловч тодорхойгүй шалтгаанаар нэвтрүүлээгүй байна.
/Энд, уг үйл явдал болсноос хойш 10 жилийн доторхи нийтлэл, нэвтрүүлгийн тоймтой заримыг дурдав/

Ховдын хөдөлгөөн, цуглааны талаар ямар нэг хэмжээний мэдээлэл бүхий хүмүүс хийгээд олон нийтийн дунд янз бүрийн санал дүгнэлт байдаг юм. Энэ нь ч зүйн хэрэг.

Нөгөө талаас, зарим хүмүүс уг үйл явдлыг Монголын олон нийтэд сайтар хүргэн таниулаагүй, түүх бичлэгт зохих ёсоор тусгуулахгүй байгаагийн бурууг уг үйл явдалд оролцож байсан хүмүүсээс эрж хайх, шахаж шаардах хандлага гаргадаг юм. Үүнийг буруутгаж болмооргүй ч, угтаа энэ нь тус цуглааныг зохион байгуулсан, оролцсон хүмүүсийн, бид бүхний ажил бус харин мэргэжлийн түүхчдийн ажил байсан бус уу? гэсэн асуулт тавихад өөрийн эрхгүй хүргэдэг юм. **Хэрвээ манай түүхчид ажлаа хийсэн шиг хийсэн бол энэхүү номыг эвлүүлэх “зовлон” бидний нуруун дээр буухгүй байх байлаа.**

Үнэнийг хэлэхэд, Ховдын хөдөлгөөн нь Монголын түүхийн хувьд “**үйлдвэрлэгдсэн атлаа түгээгдэлгүй агуулахад дарагдсан бараа лугаа адил**” үзэгдэл болж хоцорсон юм. Үүний ойр зуурын, улс төрийн шинжтэй бус, харин цаад, социаль шинжтэй учир шалтгааныг дараа тодруулан тайлбарлах болно.

Харин нэг зүйл гэвэл, 1989.12.07-ны Ховдын цуглаан болсон цаг хугацаа ба орон зайн огтлолцол, нөхцөлдөлгөөн нь өөрөө, энэхүү үйл явдлын “тавиланг” бараг эхэлж байхад нь шууд тодорхойлж орхисон тал бий. Гэхдээ энэ үйл явдлын түүхэн утга нь ирээдүйд улам гэрэлтэн тодрох тавилан юм.

Энэ “тавилан” нь дараахь “давуу” ба “сул” талуудыг өөртөө агуулж байна. Үүнд:

Давуу талууд гэвэл:

- Энэ бол улсын нийслэлд бус харин тээвэр холбооны хөгжил сул, чөлөөт мэдээллийн хэрэгсэл огт үгүй, нэг үзэл суртлын хатуу чанд хяналт бүхий социалист энэ орны нийслэлээс нь 1500 км алсад оршдог **бөглүү хязгаар нутагт боссон** ардчиллын төлөөх анхны хөдөлгөөн байсан юм.
- Энэ бол Монгол улсын түүхэн дэх **анхны /Майн 1-ний бус, Октябрийн баярын бус/ улс төрийн эсэргүүцлийн цуглаан** мөн. Мөн анхны, дээд газрын шийдвэрээр /жишээ нь, нам төрийн/ бус, хөндлөнгийн заавар болоод уруу таталтаар /жишээ нь, зарим хүний мэдэмхийрдэгчлэн Улаанбаатарынхан, Ардчилсан Холбооныхон г.м/ бус, харин оролцогсдын бор зүрхээр хийгдсэн цуглаан байв.
- Тус цуглаан дээр анх удаа 70 жилийн түүхтэй **МАХН, өөрийн тархи зүрх болсон УТГ, Сайд нарын Зөвлөлөө бүрэн бүрэлдхүүнээр нь огцруулахыг шаардсан** залуусын хилэнт үгийг домогт Ард Аюушийн талбайгаас тэр өдөр арван хэдэнтээ почирдон сонссон юм. Шаардах бичиг авсан юм.
- Энэ бол Социалист Монгол улсын түүхэнд анх удаа улс **үндэстний бие даасан байдал, үндэсний үзлийн уриа** цуурайтсан, эзэн Чингис хааныхаа хөрөг болон үгээр хүч нэмсэн анхны цуглаан байсан юм.
- Энэ бол шинэ Монголын түүхэн дэх **анхны оюутны эсэргүүцлийн цуглаан** байсан юм.
- Энэ бол тухайн үеийн ХоБДС-ийн оюутан залуус болоод Ховд хот, Ховд аймгийн төдийгүй Монголын баруун аймгуудын иргэдийг сэрээж, ардчилсан өөрчлөлтийн төлөө дуудан зоригжуулсан, “Монголын төлөө цохилох зүрхтэй байх”-ын үлгэрийг үзүүлсэн эр зоригийн цуглаан байсан юм.

“Сул” талууд гэвэл:

- Энэ бол улсын нийслэлд бус харин тээвэр холбооны хөгжил сул, чөлөөт мэдээллийн хэрэгсэл огт үгүй, нэг үзэл суртлын хатуу чанд хяналт бүхий социалист энэ орны нийслэлээс нь 1500 км алсад оршдог **бөглүү хязгаар нутагт болсон** ардчиллын төлөөх анхны цуглаан байсан юм.
- Энэ бол 90-ээд оны үйл явдлуудаас **Мэдээллийн хэрэгслээр олон нийтэд цацагдаагүй, өөрөөр хэлбэл, мэдээллийн эргэлтэд орж, Монголын олон нийтэд мэдээлэгдсэн бодит байдал болж хувираагүй анхны үйл явдал** байсан юм.
- Энэ нь ямар нэгэн **нам, холбоо байгуулаагүй, байгуулсныг зарлаагүй** цуглаан байсан юм.
- Энэ нь түүнээс хойш 3 хоногийн дараа буюу 1989.12.10-нд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, бараг тэр даруйдаа дотооддоо болон гадаадад Мэдээллийн хэрэгслүүдээр цацагдсан **Ардчилсан Холбооны анхны цуглаан болоод араас нь хөвөрсөн Ардчилсан хөдөлгөөнийхний дараа дараагийн үйл**

ажиллагаануудын дуулианд дарагдан “мартагдсан” цуглаан юм. /Энд харин нэг зүйлийг тэмдэглэхэд, хүмүүсийн дунд Ховдын хөдөлгөөнийг Ардчилсан Холбооны анхны цуглаантай хэн нь анхдагч вэ гэдгээс нь үүдэн сөргөлдүүлэн үнэлэх хандлага түгээмэл байдаг. Хэзээ юу болсон нь нэгэнт тодорхой зүйл. **Ардчилсан Холбооны зоригт хөвгүүдэд харин ч талархах учиртай.** Нэгд гэвэл, угаас нийгмийн шинэчлэлийн төлөө нэгэн адил зорилготой байсан. Ховдын цуглааныг зохион байгуулагсад, уг хэлэгсэд гэхэд л бараг бүгдээрээ Ардчилсан хөдөлгөөнийхний анхны гишүүд, дэмжигчид, зүтгэлтнүүд болсон байдаг нь нэгийг хэлэх байх. Хоёрт гэвэл, эрхбиш мэдээлэл болоод бүх талаараа стратегийн байрлал болох улсын нийслэлд байж ардаа бас ч яггүй егзөр толгойнуудтай, Ховдын хөдөлгөөнийг бодвол арай илүү зохион байгуулалттай байсан МоАХ-ны цуглаан хэрвээ 3 хоногийн дараа хийгдээгүй бол Ховдын хөдөлгөөнийхэнд хаанаас ямар цохилт ирэх байсан нь тодорхой атлаа таахын аргагүй байсан юм. НАХ хэлтэст ажлаа үргэлжлүүлэх даалгавар Намын Хорооны Товчооны хурлаас нэгэнт өгөгдчихсөн байсан нь эдүгээ цагаан дээр хараар түүх болон үлджээ.

- Эцэст нь энэ бол өөрсдөө ганц ч фото зураг дараагүй, хурал цуглааныхаа протоколыг үйлдэж хадгалаагүй, камерийн бичлэг болоод фото зургуудаа олж авч хадгалаагүй, пиараа хийж чадаагүй цуглаан юм. /Харин ямар азаар Ховд аймгийн Намын Хороо маргааш нь шуурхай хуралдаан хийж, энэхүү үйл явдлыг протоколоороо дурайтал баримтжуулсан юм бэ гэж талархах учиртай юм шүү /

Одоо, дээр нэгэнтээ дурьдаад орхисон “үйлдвэрлэгдээд түгээгдэлгүй агуулахад дарагдсан бараа” буюу энэ үйл явдлын мэдээллийн талтай холбоо бүхий асуудлыг авч үзье.

Энэ нь мэдээллийн хэрэгслийн үүрэгтэй холбогдуулан өрнөдийн зарим судлаачдын /В. Липпман/ тэмдэглэснээр, “хэвлэгдэн нийтлэгдээгүй л бол байхгүй гэсэн үг” буюу өөрөөр хэлбэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаагүй л бол тухайн цаг үеийнхнийхээ ойлгож, хүлээн авсан бодит байдлын хэсэг болох боломж тун бага гэсэн санаагаар илэрхийлэгдэж буй тэр зүйл юм. Энэ нь орчин үеийн нийгэм дэх мэдээллийн хэрэгслийн онцгой үүрэгтэй холбоотой. “Saturday Review” сэтгүүлд ийм нэгэн зураг хэвлэгджээ. Сонин уншиж суугаа ааваасаа хүү нь асууж байна. “Ааваа, хэрвээ ойд нэг мод унахад тэнд нь түүнийг дамжуулан үзүүлэх Хэвлэл мэдээллийнхэн байхгүй бол, тэр мод үнэхээр унасан уу?” Утгагүй асуулт байгаа биз?

Тийм ээ, орчин үеийн нийгэмд үнэхээр ойд мод унахад тэнд нь Хэвлэл мэдээллийнхэн байгаагүй л бол тэр мод унаагүй гэсэн үг гэж хэлэхэд тийм ч их хэтрүүлсэн болохгүй. Үүнийг уншигч та олон жишээгээр баяжуулан төсөөлж болно.

Өнөөгийн мэдээллийн технологи хөгжсөн нийгмүүдэд, жинхэнэ бодит байдал гээч нь жинхэнэ “эх бодит байдал”-аас илүүтэй, үнэн хэрэгтээ хэвлэл мэдээллийнхний сонгон авч олон нийтийн нүд чих рүү “цацдаг”, тэдний ойлголтын хэсэг болгодог тэрхүү “бодит байдал” болсоор удаж байна. Ухаан нь таны хувьд, жинхэнэ Клинтон гэж аль Клинтон бэ? Хувь хүнийхээ хувьд гэр бүл дотроо байгаа, өөрөө өөртэйгээ байгаа тэр Клинтон уу, аль эсхүл хэвлэл мэдээллээр дүр төрхийг нь бүрдүүлэн, таны төсөөлөлд өгч буй олон нийтэд цацагдаж буй тэр Клинтон уу? Юу гэхсэн бол?

“Хэвлэл мэдээллээр цацагдаагүй л бол байхгүй!”

Тийм ээ яг ийм явдал, яг ийм хувь тохиол 20 жилийн тэртээх Ховдын оюутны хөдөлгөөнийг хүлээж байсан юм. Хэрвээ тохиолдлоор ч юм уу тэр өдөр Ройтерийн нэг сурвалжлагч Ховдод тэнэж яваад Ард Аюушийн талбайд болж байсан тэр цуглаантай мөргөлдөөдөхсөн бол чухам юу болох байсан бол? Тэр өдрөө гадагшаа дотогшоо цацагдсан бол араас нь тэр жагсагчдыг, зохион байгуулагчдыг чухам юу хүлээж, ямар ямар үйл явдлууд дагалдах байсан бол? Гадагшаа дотогшоо дүлий дүмбэ оргисон тэр нийгэмд, тэр тусмаа тэр хязгаар нутагт тэрүүхэн тэндээ бас ч багагүй бужигнаантай байсан өдрүүдийг одоо эргэн санахлаар өөрийн эрхгүй ийм асуулт толгойд орж ирээд байдаг юм.

1990-ээд онуудад Зүүн Европ болон ЗХУ-ын нөлөөний улс орнуудад болсон үйл явдлуудыг “Телевизийн хувьсгал” гэж өрнөдийн судлаачид нэрлэсэн нь санамсаргүй хэрэг биш юм.

- Телевизийн хувьсгал!
- Телевиз байтугай радио, сониноор ч цацагдаагүй Ховдын хөдөлгөөн!

Ийм л юм болж.

Зарим хүн энэ үйл явдалтай холбогдуулан “Ховдынхон чинь зүгээр л МАХН-ын Бүгд хуралд захидал явуулах гэж цугласан юм байх чинь билээ, сүйд болох юм биш” гэх маягийн үг хэлсэн байх. Хэн юу хэлэх нь өнөөдөр бол бүр ч дурын асуудал болж. Харин энэ эрхийг олгуулахын тулд тэр хар нялхаараа оюутан залуус тэр өдөр санаандаа ч багтаагаагүй эрсдлүүдийг эс тоон боссон юм гэдгийг санаж байхад илүүдэх юун.

Түүнээс гадна тэр “захиа” хайрын захиа байгаагүй. Хоёрт гэвэл, тэр залуус МАХН-ын УТТ-г огцруулах тухай шаардлагаа биелүүлэхийн тулд саарал ордонг гороолоход ч бэлэн байсан юм шүү. Харин харамсалтай нь ингэхийн тулд тэр 300 залуус Улаанбаатар луу явган марш хийхээс аргагүй байсан бөгөөд /тэр үед манай БНМАУ-д УБ – Ховдын хооронд нислэг хийдэг байсан АН-24-т үсрээ л 50 хүн багтдаг, тэгээд тэр нь халуун савны оочер шиг социализмын нэг бахархал болсон нуль оочертой байдаг байв/ тэд хоногийн 24 цагийн талд нь алхаад байлаа гэхэд л 25 өдөрт арайхийж Нийслэл хүрээнд орж ирэхээр байв шүү. Дээрээс нь иймэрхүү төрлийн мэдээнд Үнэн сонин харааны бэрхшээлтэй, ганц сувагтай Үндэсний телевиз хараа болоод сонсголын бэрхшээлтэй, Монголын радио чихээ мушгиулдаг байсан цаг. Ийм нөхцөлд эхний ээлжинд авах нэг арга хэмжээ нь “хайрын захиа” л байсан юм даа.

1989.12.07-ны өдөр Ховд хотноо Ард Аюушийн талбайд болсон цуглаан дээр хэн ч нам болон холбоо байгуулсныг зарлаагүй, хэн ч Монголд Ардчилсан хувьсгалыг эхлүүлээ гэж зарлаагүй. Хэн нь ч 3 хоногийн дараа Улаанбаатарт болох гэж буй МоАХ-ны анхны цуглааны талаар мэдээлэлгүй байсан. **Энэ хоёр үйл явдлын хооронд утгын холбоо байсан, харин шалтгаант холбоо байгаагүй юм.** Энэ бол түүхэн үнэн.

Гэхдээ энэ л цуглаан дээр, алс баруун хязгаарын Ховд нутгийн тэнгэр дор, нэг гартаа гинжээ барин, нөгөө гартаа заргын бичгээ атган бурангуй засаглалын эсрэг шазуур зуун боссон Ард хэмээгдэгч Аюушийн хөшөөний дэргэдээс, тэр цагийн Ховд болоод баруун аймгуудын оюуны цөм болж асан Ховдын Багшийн Дээд Сургуулийн хориодхон насны босгыг дөнгөж алхсан оюутан залуус “Улс Монголынхоо төлөө нэгдэцгээе!!!” гэсэн утга төгөлдөр уриан дор нэгдэж, төрийн социализмын төмөр нударга, далд хяналтын дор, тэр цагийн хамаг шүтээн болсон МАХН-ын Улс Төрийн Товчоо болон Сайд нарын Зөвлөлийг бүрэн бүрэлдхүүнээр нь огцруулахыг шаардсан Өргөх бичиг үйлдэн босож, залуу насны халуун эх оронч сэтгэл, эр зоригийн жинхэнэ жишээг үзүүлж чадсан юм.

Энэ бол бас хөдөлшгүй түүхэн үнэн юм.

2009 оны 11 дүгээр сарын 29
Улаанбаатар хот